



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.07.25 № 27

**Агаарын бохирдлыг бууруулах
төсөл хөтөлбөрүүдийн талаар**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг үндэслэн улсын хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн болон 2026 онд төлөвлөж буй төсөл, арга хэмжээ, хөтөлбөрүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, төсөв, хэрэгжилтийн үр дүн, ирээдүйн төлөвлөгөөний талаар дараах асуултыг Танд тавьж байна.

1.Улсын хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2020 оноос хойш өнөөдрийг хүртэл хэрэгжүүлсэн болон одоо хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ, бодлогын хөтөлбөрүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах агуулга бүхий төсөл тус бүрээр нь ангилж ирүүлэх. Үүнд:

1.1.Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, орлуулах түлшний татаас олгох хөтөлбөр;

1.2.Айл өрх болон нийтийн орон сууцны дулаалгыг дэмжих төсөл, арга хэмжээ;

1.3.Эрчим хүчний хэмнэлт бий болгох болон сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхтэй холбоотой төсөл, хөтөлбөрүүд;

1.4.Айл өрхүүдэд халаалтаа цахилгааны эх үүсвэр, сэргээгдэх эрчим хүчээр шийдэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн дэд станц, дамжуулах шугамыг сайжруулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг байршил болон өртгөөр.

2.Дээрх төсөл, арга хэмжээ бүрийн жил бүрийн төсөв, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

3.Хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт.

2025000042

4.2026 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болон шинээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээ, хөтөлбөр, түүнд шаардагдах төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан ирүүлэхийг танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Г.ЛУВСАНЖАМЦ

2025000042